Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандарттай нийцүүлсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8,920,698.3 мянган төгрөгөөр буюу 5.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	9,847,937.4	13,680,257.8	3,832,320.4
Авлага	9,568,667.4	52,574.2	(9,516,093.2)
Бараа материал	87,410,262.2	92,301,435.8	4,891,173.5
Үндсэн хөрөнгө	50,370,337.7	60,083,635.2	9,713,297.5
Нийт хөрөнгө	157,197,204.7	166,117,903.0	8,920,698.3
Өр төлбөр	4,211,601.2	65,251.4	(4,146,349.8)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	152,985,603.5	166,052,651.6	13,067,048.1
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	157,197,204.7	166,117,903.0	8,920,698.3

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн дансдууд өмнөх оноос нөлөө бүхий өөрчлөлттэй байна. Тухайлбал,

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 13,680,257.8 мянган төгрөгт хүрч 3,832,320.4 мянган төгрөгөөр өссөн нь гүйцэтгэлээрх санхүүжилтийн үлдэгдэл, өмнөх онд ЭМЯ-наас лабораторийн тоног төхөөрөмж худалдан авах зорилгоор эрх шилжүүлсэн 7,048,000.0 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдэл байгаагаас;
- Авлагын дансны үлдэгдэл 9,516,093.2 мянган төгрөгөөр буурсан нь Эрүүл мэндийн даатгалын сангаас өмнөх оны санхүүжилтийн үлдэгдэл 9,555,554.0 мянган төгрөгийг шилжүүлсэн авсантай;
- Бараа материалын дансны үлдэгдэл 92,301,435.8 мянган төгрөгт хүрч 4,891,173.5 мянган төгрөгөөр өссөн нь ЭМЯ-наас үнэ төлбөргүйгээр 17,901,633.3 мянган, олон улсын болон бусад байгууллагын хандив тусламжаар 25,282,284.3 мянган, мөн 22,478,146.1 мянган төгрөгийн худалдан авалтаар тус тус нэмэгдсэн байна. Үнэ төлбөргүй болон хандив тусламжаар хүлээж авсан бараа материалын 27,448,200.8 мянган төгрөгийн 63.5 хувийг вакцин эзэлж байгаа бөгөөд тайлант онд 30,092,165.5 мянган төгрөгийн вакциныг зарцуулсан. Бараа материалын дансанд тусгай зориулалтын материал 2,566,561.3 мянган, эм боох материал 86,181,399.1 мянган, хангамжийн материал 3,553,475.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна;
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 60,083,635.2 мянган төгрөгт хүрч 9,713,297.5 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь ЭМЯ-ны хөрөнгө оруулалтаар хийсэн их засвараар эмнэлгийн барилгыг капиталжуулсан 3,677,330.6 мянган, үнэ төлбөргүй болон хандив тусламжаар хүлээж авсан 8,032,011.0 мянган, төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 2,380,200.8 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна;
- Өр төлбөр данс 4,146,349.8 мянган төгрөгөөр буурсан нь нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийн 368,855.4 мянган, эмийн тооцооны 2,473,821.2 мянган, урсгал засварын 1,031,244.7 мянган төгрөгийн өр төлбөрийг барагдуулсантай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг Эрүүл мэндийн даатгалын сангаас 38,823,543.5 мянган, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 37,880,353.2 мянган, нийт зарлагыг 76,703,896.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлж, батлуулсан байна.

Төсвийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл нь тайлант хугацааны төсвийн төсөлтэй уялдаж, Төсвийн тухай хуульд заасан төсвийн шаардлагад нийцсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Халдварт өвчин судлалын үндэсний төв нь эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн хүрээнд гүйцэтгэлээр санхүүжиж байгаа бөгөөд тайлант онд Эрүүл мэндийн даатгалын сангаас 36,303,283.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлого 21,604,913.2 мянган, туслах үйл ажиллагаанаас 10,977,994.7 мянган, нийт 68,886,191.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 65,056,052.8 мянган төгрөгийг зарцуулж 13,680,257.8 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 65,056,052.8 мянган төгрөг буюу 84.8 хувьтай байгаа нь цалин хөлс, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 1,004,512.2 мянган, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 516,200.1 мянган, хангамж бараа материалын зардлыг 225,564.5 мянган, нормативт зардлыг 3,628,188.5 мянган, эд хогшил, урсгал

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

засварын зардлыг 5,687,668.9 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
	Код	Нэр			Зөрүү	Биелэлт
1	71602	Эмнэлгийн тусламж үйлчилгээ	76,703,896.7	65,056,052.8	11,647,843.9	84.8
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	57,512,118.4	52,797,274.8	4,714,843.6	91.8
1.2	80802	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	251,812.9	221,580.0	30,232.9	88.0
1.3	83601	Нэмэлт - Олон улсын байгууллагаас олгосон	6,406,394.7	5,743,145.4	663,249.3	89.6
1.4	83603	Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан	12,533,570.7	6,294,052.6	6,239,518.1	50.2

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн анхан шатны иж бүрэн баримтыг үндэслэн бүртгэл хөтлөх, программын хөгжүүлэлт хийж дотоод хяналтыг сайжруулах, удирдлагын зөвлөлийн шийдвэрийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд гаргахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Нью эстимэйтор аудит ХХК-ийн газрын аудитор Б.Халиунаа, аудитор Б.Алтанцэцэг нар гүйцэтгэж, хяналтыг захирал Ж.Үхэртар хэрэгжүүлсэн.

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Нью эстимэйтор аудит ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 1-1/141 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 366,794,621.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 5,501,919.3 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзэв. 2022 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого өмнөх оны орлогоос буурсан тул гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг шинэчлэн тогтоож 1,683,721.3 мянган төгрөг болов.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагын цахилгаан халаалтын температурыг ажлын бус цагаар багасгаж тог цахилгааныг хэмнэх зохицуулалт хийж өмнөх оноос байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 7,603.7 мянган төгрөгөөр хэмнэсэн байна. Мөн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж төлбөр барагдуулах хуваарь гарган, нийт өр төлбөрийн 98.5 хувийг барагдуулсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд Төсвийн шууд захирагчийн мэдээлбэл зохих орлогын 57,794,845.9 мянган төгрөгийн 425, зарлагын 50,720,721.8 мянган төгрөгийн 1203, бусад 94,489,719.3 мянган төгрөгийн 616, нийт 203,006,287.0 мянган төгрөгийн 2228 мэдээллийг хугацаанд нь, 16 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

ТБОНӨХБАУХАТ хуулийн дагуу барилга байгууламжийн засвар үйлчилгээ, эм, эмнэлгийн хэрэгсэл, өндөр өртөгт мэс заслын хэрэгсэл, аж ахуй, хангамжийн материал, шатахуун, хүнсний материал худалдан авах тендерийг цахимаар нээлттэй, харьцуулалтын аргаар сонгон шалгаруулалт хийж, шалгарсан байгууллагуудтай гэрээ байгуулсан байна. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн тус хуулийн хүрээнд шалгасан дараах зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

Гэрээнээс түүвэрлэн шалгахад Монфа трейд ХХК, Мөнхийн тун ХХК, Энто ХХК, Монос трейд ХХК, Лайфтроник ХХК, Медклийн ХХК, Медконт ХХК, Их шүүдэргэнэ импорт ХХК-тай нийт 1,854,018.9 мянган төгрөгийн гэрээг байгуулж, 2022 оны 8 сарын 31-ний өдөр гэрээний хугацаа дуусах заалттай хэдий ч 594,102.1 мянган төгрөгийн эм эмнэлгийн хэрэгслийг гэрээний хугацаанд хүлээж аваагүй, хэрэгжилтийг хангуулж ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр, бараа үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49.2.1-д "Гэрээг дүгнэж, бараа, ажил үйлчилгээг хүлээн авсан баримт бичиг" тендерийн хавтаст хэрэгт байна гэж заасантай", Мөн төвийн эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах гэрээний 2.3 Захиалагчийн эрх үүрэг 2.1-д "Нийлүүлэгчтэй байгуулсан гэрээгээр тогтоосон график хугацаанд захиалсан барааг нэр төрөл, тоо ширхгээр хүлээн авах ба тогтоосон хугацаанд барааг нийлүүлэхийг нийлүүлэгчээс шаардана", 2.7-д "Гэрээгээр нийлүүлбэл зохих барааг нэр төрлөөр, тоо хэмжээгээр дутуу нийлүүлсэн, эсхүл нийлүүлэхээр тохиролцсон хуваарьт хугацааг хэтрүүлсэн тохиолдолд барааг нийлүүлбэл зохих өдрийн дараагийн өдрөөс эхлэн хоног тутамд нийлүүлээгүй барааны үнийн дүнгээс 0.5 хувийн алданги тооцно" гэж заасантай тус тус нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Бэлтгэн нийлүүлэгчийн гэрээний үүргийг хангуулж, түүний хэрэгжилтэд хяналт тавин эм эмнэлгийн хэрэгслийг бүрэн авч байх, зөрчлийг давтан гаргахгүй байх, албан шаардлага өгөх.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнд нийт 4,625,829.7 мянган төгрөгийн 6 асуудлыг илрүүлж, асуудлын бүртгэлээр зөвлөмж өгсөн ба жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад 1,428,825.8 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг залруулсан байна. Биелэлт хангалтгүй 3,197,003.9 мянган төгрөгийн 1 зөрчлийг тайлант оны аудитын тайланд тусгасан болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1,662,661.1 мянган төгрөгийн 6 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн, 26,678,840.1 мянган төгрөгийн албан шаардлагаас 314,290.0 мянган төгрөгийн зөрчлийг дутуу хэрэгжүүлж, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн, албан шаардлага зөвлөмжийн хэрэгжилт 98.8 хувьтай байна.

Хүснэгт-3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-	-	-
Албан шаардлага	5	26,678,840.1	4	26,364,550.1	1	314,290.0	98.8
Зөвлөмж	6	1,662,661.1	6	1,662,661.1	-	-	100.0
Нийт дүн	11	28,341,501.2	10	28,027,211.2	1	314,290.0	98.8

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

- Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн хүрээнд гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн системд шилжиж, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн үйл ажиллагааг бусад эмнэлгүүдийн адил зөвхөн Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр болсон. Тус төв нь өмнөх онд ЭМДС-аас 46,567,931.4 мянган төгрөгийн санхүүжилт авсан бол тайлант онд 26,747,729.4 мянган төгрөг болж буурсан байна. ЭМДС-ийн санхүүжилт нь зөвхөн тусламж үйлчилгээ, эмчилгээнд зориулагдаж байгаа учир төвийн хэвийн үйл ажиллагааг хангахад хүрэлцэхгүй байх эрсдэлтэй. Иймд тус төвийн үндсэн чиг үүргийн зарим хэсэг тухайлбал: халдварт өвчний урьдчилан сэргийлэлт, тандалт судалгаа, үндэсний хэмжээнд эмчилгээний асуудлыг удирдан зохион байгуулах, мэргэжил арга зүйгээр хангахтай холбоотой үйл ажиллагааны зардлын санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхой болгох шаардлагатай.
- Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/389 тушаалаар эрх шилжүүлсэн 7,044,000.0 мянган төгрөгийн үлдэгдэл 5,952,006.8 мянган төгрөгийн зарцуулалтыг шалгах.
- Глобал сангаас Сүрьеэгийн /тубис/ цахим бүртгэл, мэдээллийн системийн хөгжүүлэлт хийж, аюулгүй тогтвортой байдлыг хангуулах зорилгоор 3 жилийн хугацаатай нийт 57.0 мянган ам.долларын санхүүжилт олгохоор болсон бөгөөд 2021 онд олгосон 30.0 мянган ам.долларын санхүүжилтээр "Метекс плас ХХК"- тай гэрээ байгуулж, 2022 онд гэрээт ажлыг гүйцэтгэсэн. Дараагийн аудитаар системийн хөгжүүлэлттэй холбоотой 27.0 мянган ам.долларын санхүүжилтийн гүйцэтгэлийг шалгах шаардлагатай.
- Тус төвийн эм боох материалд 57,281,716.1 мянган төгрөгийн өртөгтэй 2,366,658 хүн тун ковидын вакцин үлдэгдэлтэй байгаагийн 1,006,050 хүн тун вакцин нь 2023 оны 1 дүгээр сард хугацаа нь дууссан, 1,221,018 хүн тун нь 2-4 дүгээр саруудад, 139,590 хүн тун вакцин нь 7 дугаар сард тус тус хугацаа дуусахаар байна. ХӨСҮТ-д ковидын эсрэг вакциныг Ковакс хөтөлбөрийн хүрээнд ЭМЯ-с үнэ төлбөргүйгээр олгодог бөгөөд тайлант онд зөвхөн ковидын эсрэг хүүхдийн вакцин 302,400 мянган хүн тунг хүлээн авч 162,810 тунг зарцуулжээ. Ковакс хөтөлбөрийн хүрээнд Монгол улсын Засгийн газраас нийт иргэдийг 4 тунд хамруулах зорилт тавьсан хэдий ч 2022 оны 4 дүгээр улирлын байдлаар нийт иргэдийн 4.2 хувь буюу 139,048 иргэн л бүрэн тунд хамрагдсан байна. Хугацаа дууссан болон хугацаа нь дуусах дөхөж буй ковидын эсрэг вакцины асуудлыг дараагийн аудитаар анхаарах шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 989,999.7 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 768,445.1 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 221,554.6 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

5.2 Албан шаардлага

Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/377 дугаар тушаалаар "Халдварт өвчин судлалын үндэсний төвийн үйл ажиллагаанд шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслийн жагсаалт техник үзүүлэлт"-ийг баталж, нийлүүлэгчийг сонгон шалгаруулан гэрээ байгуулах эрхийг тус төвд шилжүүлсэн боловч тус төвийн Ерөнхий захирлын 2021 оны 6 дугаар сарын 30-ний А/127 тушаалаар томилсон үнэлгээний хороо нь захиалагчийн техникийн үзүүлэлтээс зөрүүтэй тодорхойлолт бэлтгэн худалдан авах ажиллагааг зохион байгуулж, 768,445.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг хүлээн авсан байна.

ТБОНӨХБАҮХАТ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.19 "техникийн тодорхойлолт" гэж захиалагч худалдан авах бараа, ажил, үйлчилгээний техникийн үзүүлэлт, үйлдвэрлэл, үйл ажиллагааны арга, технологи, түүнд тавих технологийн шаардлагыг тодорхойлсон бүрдүүлбэрийг; 47 дугаар зүйлийн 47.2-т "Үнэлгээний хороо байнгын бус ажиллагаатай байх бөгөөд дор дурдсан чиг үүрэгтэй байна" 47.2.1-т "техникийн тодорхойлолт бэлтгэх, тендерийн урилга, тендерийн баримт бичгийг боловсруулах, тендер хүлээн авах, тендер нээх ажиллагааг холбогдох зааврын дагуу гүйцэтгэх" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдэл хангагдахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үнэлгээний хороо нь техникийн тодорхойлолт бэлтгэхдээ захиалагчийн саналаас зөрүүтэй бэлтгэхгүй байх, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулах, албан шаардлага өгөх.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Хашхан ХХК-с хандив тусламжаар 71,811.5 мянган төгрөгийн тавилга, эд хогшлыг хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар хүлээн авч, санхүүгийн тайланд тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Хандив тусламжаар ирсэн хөрөнгө, бараа материалыг иж бүрэн анхан шатны баримтад үндэслэн санхүүгийн тайланд тусгах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

1. Нэмэгдэл цалинтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус төвийн удирдах зөвлөлийн 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн хурлаар Гашуун Сухайт боомтод ээлжээр ажиллах ажилчдын нэг өдрийн нэмэгдэл хөлсийг ээлжийн ахлагч

180.0 мянга, эмч нягтлан бодогч 170.0 мянга, бусад ажилчдад 150.0 мянган төгрөгөөр тооцож олгохоор шийдвэрлэсэн бөгөөд Гашуун сухайт боомтод ажилласан ажилчдад 288,148.6 мянган төгрөгийн үндсэн цалин, 1,565,400.3 мянган төгрөгийн нэмэгдэл цалинг олгосон байна. Энэ нь дээрх ажилчид хилийн боомтод ажиллах хугацаанд үндсэн цалинг ойролцоогоор 4 дахин нэмэгдүүлсэн буюу 973,173.1 мянган төгрөгийн нэмэгдэл хөлс авсан байна. Мөн тушаал шийдвэрийн зөрүүтэй 149,743.1 мянган төгрөгийн нэмэгдэл хөлс тооцсон байна.

Энэ нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Төрийн үйлчилгээний албан хаагчдад орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журмын 2-т "Орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны нэмэгдлийг дараах албан тушаал эрхэлж байгаа эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчид албан тушаалын сарын үндсэн цалингаас дор дурдсан хувиар бодож сар бүр олгоно", "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ын 2.Нэмэгдэл хөлс тооцох аргачлал 2.5-д "Ээлжээр ажилладаг албан хаагчийн ээлж долоо хоногийн амралтын болон нийтээр амрах баярын өдөр таарсан бол долоо хоногийн амралтын болон нийтээр амрах баярын өдрөөр ажилласны нэмэгдэл хөлс олгохгүй" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

ХӨСҮТ-ийн удирдах зөвлөлийн гишүүд нь цалин, нэмэгдэл хөлстэй холбоотой аливаа шийдвэрийг Хөдөлмөрийн тухай хууль, түүнтэй холбогдон гарсан журам, зааврын хүрээнд гаргаж байх.

2. Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд Эрүүл мэндийн даатгалын сангаас 30,766,812.6 мянган төгрөг нэхэмжилж хяналтаар 4,019,083.2 мянган төгрөг хасагдуулга гарсан нь Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолын тусламж үйлчилгээний шалгуур хангаагүй, тарифын зөрчилтэй, өвчний хүндийн зэрэг ахиулж үнэлсэн, өвчтөнг эмнэлгээс гаргах шалгуурыг мөрдөөгүй, нэг даатгуулагчийг давхар нэхэмжилсэн, даатгалгүй иргэдэд тусламж үзүүлсэн, регистрийн дугаар алдаатай зэргээс шалтгаалжээ.

Энэ нь ЭМДҮЗ-ийн 2022 оны 01,02 дугаар тогтоол "Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай" 2.4.1-д "эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хяналт, санхүүжилт, төлбөр тооцооны программ, цахим системийг бодит цагийн горимд шилжүүлж, энэ тогтоолын хавсралтаар баталсан тусламж, үйлчилгээний өртөг, тариф болон журамд заасан зохицуулалттай холбоотой хөгжүүлэлт хийх үйл ажиллагаандаа мөрдөх", 2022 оны 12 дугаар тогтоол "Журам батлах тухай" 4.2.2.2-т "эрүүл мэндийн байгууллага нь чанар, төлбөрийн хяналт хийж нэхэмжлэлийг хянах шалгуурын дагуу хөгжүүлсэн ЭМДЕГ-ын цахим системд холбогдсон, мэдээллийн өгөгдөл нь нийцсэн цахим системтэй байх, 4.2.2.4-т "Чанар, төлбөрийн хяналтыг хийж нэхэмжлэлийг хянахад шаардагдах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний анхан шатны маягт болон санхүүгийн баримтыг ЭМДЕГ-т гаргаж өгөх" гэж заасантай нийцэхгүй, "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Программын хөгжүүлэлтийг тогтмол хийх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний анхан шатны маягтыг иж бүрэн бэлтгэх, дотоод хяналтыг алба, хэлтэс, тасаг бүрт сайжруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 09 дүгээр сарын 01 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хашхан ХХК-с хандив тусламжаар 71,811.5 мянган төгрөгийн тавилга, эд хогшлыг хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар хүлээн авч, санхүүгийн тайланд тусгасан.	1	71,811.5					1	71,811.5		
Тайлант онд Эрүүл мэндийн даатгалын сангаас 30,766,812.6 мянган төгрөг нэхэмжилж хяналтаар 4,019,083.2 мянган төгрөг хасагдуулга гарсан нь Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолын тусламж үйлчилгээний шалгуур хангаагүй, тарифын зөрчилтэй, өвчний хүндийн зэрэг ахиулж үнэлсэн, өвчтөнг эмнэлгээс гаргах шалгуурыг мөрдөөгүй, нэг даатгуулагчийг давхар нэхэмжилсэн, тусламж үйлчилгээ авсан иргэн даатгал төлөгч биш, регистрийн дугаар алдаатай зэргээс шалтгаалжээ.	1	-					1	-		

Захиалагчийн тодорхойлсноос зөрүүтэй техникийн тодорхойлолт бэлтгэж, үндсэн хөрөнгийг хүлээн авсан	1	768,445.1			1	768,445.1						
Удирдах зөвлөл хилийн боомтод ажиллах ажилчдын нэмэгдэл цалин хөлсийг үндэслэлгүй тогтоосон, зарим тооцсон нэмэгдэл хөлс нь тушаал шийдвэрээс зөрүүтэй.	1	149,743.1					1	149,743.1				
Дүн	4	989,999.7			1	768,445.1	3	221,554.6				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга		Нийт зөрчил		Үүнээс						/мянган төгрөгөөр/	
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил											
Бэлтгэн нийлүүлэгчтэй хийсэн гэрээний хэрэгжилтэд хяналт тавиагүй, гэрээний үүргийг хангуулаагүй, хоцорсон хугацаанд алданги ногдуулаагүй.	1	594,102.0			1	594,102.0					
Дүн	1	594,102.0			1	594,102.0					

/мянган төгрөгөөр/



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 дугаар сарын 24 № 260/А0150127
СНАГ - 2023/360/НА - СТА - ТШЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үнэлгээний хороо нь 768,445,080.00 төгрөгийн цахим систем нэвтрүүлэх, тоног төхөөрөмжийг захиалагчийн тодорхойлсон үзүүлэлтээс зөрүүтэй техникийн тодорхойлолт бэлтгэн худалдан авах ажиллагааг зохион байгуулж, хүлээн авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.19-д "техникийн тодорхойлолт" гэж захиалагч худалдан авах бараа, ажил, үйлчилгээний техникийн үзүүлэлт, үйлдвэрлэл, үйл ажиллагааны арга, технологи, түүнд тавих технологийн шаардлагыг тодорхойлсон бүрдүүлбэрийг; 47 дугаар зүйлийн 47.2-т Үнэлгээний хороо байнгын бус ажиллагаатай байх бөгөөд дор дурдсан чиг үүрэгтэй байна: 47.2.1-т "техникийн тодорхойлолт бэлтгэх, тендерийн урилга, тендерийн баримт бичгийг боловсруулах, тендер хүлээн авах, тендер нээх ажиллагааг холбогдох зааврын дагуу гүйцэтгэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Үнэлгээний хороо нь захиалагчийн баталсан үзүүлэлт, тоо хэмжээний дагуу техникийн тодорхойлолт бэлтгэн, худалдан авах ажиллагааг зохион байгуулах, түүнд хяналт тавьж ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Стратеги төлөвлөлт, гадаад харилцаа эрхэлсэн дэд захирал Д.Баярсайхан, эдийн засагч А.Шинэхүү нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
НЬО ЭСТИМЭЙТОР АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.БОЛД
Ж.ҮХЭРТАР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga 2023 0224 SNAГ 116.docx

0001080497



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 дугаар сарын 24

№ 259/A0150127

Улаанбаатар хот

СНАГ-2023/360/НА-
-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 594,102,009.00 төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг гэрээний хугацаанд хүлээж аваагүй, худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьдаггүй, гэрээний дагуу алданги тооцоогүй, гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 зүйлийн 49.2.1 "Гэрээг дүгнэж, бараа, ажил, үйлчилгээг хүлээж авсан баримт бичиг" тендерийн хавтаст хэрэгт байна, Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах гэрээний 2. Захиалагчийн эрх үүрэг 2.1-д "Нийлүүлэгчтэй байгуулсан гэрээгээр тогтоосон график хугацаанд захиалсан барааг нэр төрөл, тоо ширхгээр хүлээн авах ба тогтоосон хугацаанд барааг нийлүүлэхийг нийлүүлэгчээс шаардана", 2.7 "Гэрээгээр нийлүүлбэл зохих барааг нэр төрлөөр, тоо хэмжээгээр дутуу нийлүүлсэн, эсхүл нийлүүлэхээр тохиролцсон хуваарьт хугацааг хэтрүүлсэн тохиолдолд барааг нийлүүлбэл зохих өдрийн дараагийн өдрөөс эхлэн хоног тутамд нийлүүлээгүй барааны үнийн дүнгээс 0.5 хувийн алданги тооцно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Бэлтгэн нийлүүлэгчийн гэрээний хугацааг хэрэгжүүлж ажиллахад хяналт тавих, нийлүүлээгүй барааны үнийн дүнд гэрээний дагуу алданги тооцох, гэрээ дүгнэсэн акт үйлдэж, тендерийн хавтаст хэргийг иж бүрэн бүрдүүлэх, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төвийн захирал Ц.Билэгтсайхан, Стратеги төлөвлөлт, гадаад харилцаа эрхэлсэн дэд захирал Д.Баярсайхан нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
НЬЮ ЭСТИМЭЙТОР АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ч.БОЛД
Ж.ҮХЭРТАР

Утас: +976 51 261585
Факс: +976 11 323266, 324653

Цахим шуудан: info@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

Хаяг: Засгийн газрын IV байр
Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг